



**ШИНЭ ИХ ТЭРБҮМ  
АУДИТ ХХК**

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
1-р хороо, 12-р хороолол, North center, 204 тоот  
Утас: 9919-9075, 8804-3708, И-мэйл: Ikhterbum@gmail.com

2023-08-27 № 23/37  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г “ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ИЙН Г  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**

**Дүгнэлт**

Бид “Жуулчин дюти фрий” ХК (цаашид “Компани” гэх)-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, нэмэлт тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр компанийн санхүүгийн тайлангууд нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (“АОУС”)-ын дагуу хийж гүйцэтгэв. Эдгээр стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагаа энэ тайлангийн Санхүүгийн тайланд аудиторын хүлээх үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулсан.

Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл (“НБЕЗОУСЗ”)-ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон Монгол улсад мөрдүүлэхээр шаарддаг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус байсан бөгөөд НБЕЗОУСЗ-ийн дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагын дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

**Тасралтгүй үйл ажиллагааны зарчимтай холбоотой асуудал**

Тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой материаллаг тодорхой бус байдал бидэнд ажиглагдаагүй.

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)**  
**“Жуулчин дүти фрий” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд**

**Аудитын гол асуудал**

Аудиторын мэргэжлийн үнэлэмжээр “аудитын гол асуудал” гэдэг нь тайлант жилийн санхүүгийн тайланд аудитад хамгийн ихээр нөлөө үзүүлэхүйц зүйлс болно. Эдгээр асуудлууд нь санхүүгийн тайланг бүхэлд нь хамарсан, аудитын ажлын агуулга болон дүгнэлтийн хэлбэрт тусгалаа олсон тул тусгайлсан санал, дүгнэлт гаргаагүй.

**Бусад мэдээлэл**

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (“ТУЗ”), хэрвээ байхгүй бол гүйцэтгэх удирдлага нь бусад мэдээллийг бэлтгэх үүрэгтэй. Бусад мэдээлэл нь ТУЗ-ийн тайлангийн хавсралт, бизнесийн хариуцлагын тайланг багтаасан мэдээллээс бүрдэнэ. Санхүүгийн тайланд хийсэн аудиттай холбогдуулан бидний үүрэг бол бусад мэдээлэлтэй танилцах бөгөөд бусад мэдээлэл нь бие даасан санхүүгийн тайланд эсвэл аудитаар олж авсан бидний мэдлэг эсвэл өөр хэлбэрээр материаллагаар буруу илэрхийлэгдсэн байж болох эсэх талаар авч үзэх явдал юм. Энэ талаар бидэнд мэдээлэх зүйл байхгүй болно.

**Санхүүгийн тайланд компанийн удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага**

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах болон алдаа эсвэл залилангаас үүдэлтэй материаллаг алдаатай илэрхийллээс ангид санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг тодорхойлох нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага нь компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Засаглах удирдлага нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

**Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага**

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг цаг ямагт илрүүлдэг гэсэн баталгаа гаргадаггүй.

Алдаа зөрчил нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)**  
“Жуулчин дютти фрий” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

**Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага (үргэлжлэл)**

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын явцад мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь залиланд хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох явдлууд орсон байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдал санал дүгнэлт өгөх зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горим боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг авч үздэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын нотолгоонд үндэслэн компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсэх үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийг тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангах хэмжээнд гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

**Тайлангийн хэрэглээ**

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу зөвхөн Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулсан ба бусад өөр этгээдэд зориулаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд бусад аливаа нэгэн гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.



Д.Дантулам-Гүйцэтгэх захирал, МНБ

ШИНЭ ИХ ТЭРБУМ АУДИТ  
№ 6